

БАТЛАВ.
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГА Э.ТҮВШИНЧУЛУУН



2024 оны 03 сарын 05 өдөр

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Зорилтод түвшин	Хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан
Зорилго 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх;						
1.	1.1. Эрчим хүчний хууль тогтоомж, хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээг сурталчилах, тайлбарлан таниулах зорилгоор “Хэрэглэгчийн нээлттэй өдөрлөг”-ийг зохион байгуулах;	Үйл ажиллагааны зардлаар	Хэрэглэгчийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, эрчим хүчний хангамжийн чанар, хэмнэлт, СЭХ-ний тархмал үүсгүүр, техникийн нөхцөл, шинэ холболт, ухаалаг тоолуур зэргийн талаар таниулах;	Эрчим хүчний 20-иос доошгүй компани, байгууллагуудыг хамруулж хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлсэн байна.	6-р сар	АА ЗУГ
	1.2. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/ байгууллагын албан ёсны цахим хуудас; б/ сошиал сувгууд; в/ дотоод сүлжээ; г/ мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, д/ бусад хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх;	Үйл ажиллагааны зардлаар	Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх;	Бүх контентуудыг байршуулж сурталчилсан байна.	жилдээ	АА М.Мөнхтулга ЗУГ Д.Энхтүвшин Б.Батбаяр
	1.3. Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материалд авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэл 1-110 дугаарыг оруулан сурталчлах;	Үйл ажиллагааны зардлаар	Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн, 2-оос доошгүй хэвлэмэл материалд оруулсан байх;	ЭХЗХ-оос эрхлэн гаргадаг Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд, жилийн тайлан, сэтгүүлд сурталчилсан байна.	1-р улирал	АА М.Мөнхтулга ЗУГ Д.Энхтүвшин
	1.4. Өөрийн байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контентыг олон нийтэд хүргэсэн байх;	Үйл ажиллагааны зардлаар	- Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх;	Видео контент 30,000-аас доошгүй үзэлттэй байх;	жилдээ	ЗУГ Б.Батбаяр Д.Энхтүвшин

			-Видео контентын хандалтын тоо;			
Зорилго 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах;						
2.	2.1. Байгууллагаас олгосон эрчим хүчний тусгай зөвшөөрөл, аудитор, аудитын байгууллагын эрх, хэрэглэгчийн үнэ тарифын талаарх мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй байлгах, Хорооны цахим хуудсанд байршуулах;	Үйл ажиллагааны зардлаар	-Тусгай зөвшөөрөл, эрх олголт, үнэ тарифын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангасан байна.	Нийт 5 бүлэг мэдээллийг цахим хуудсанд тогтмол байршуулсан байна.	жилдээ	ТЗГ, ҮТГ, ЭХХГ Д.Ганзориг Б.Уламбадрах Л.Заяа
	2.2. Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийг хэрэглэгчийн өргөдөл, гомдлын цахим системд хамруулж орон нутгийн хэрэглэгчдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хамтран ажиллах,	Үйл ажиллагааны зардлаар	Цахим системд хамрагдсан зохицуулах зөвлөлүүд	22 зохицуулах зөвлөл	1-р улирал	Ажлын алба ХОНГ Д.Алтантуяа
	2.3. Байгууллагын 2025 оны ажлын тайлан, төсвийн гүйцэтгэлийг тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, байгууллагуудад тайлагнах, аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг нийтлэх;	Үйл ажиллагааны зардлаар	- Зохицуулалтын үйлчилгээний хөлс төлдөг нийт компаниудад тайлагнах; -Байгууллагын үйл ажиллагаа, төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах;	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 130 компани, байгууллагад тайлагнасан байх;	2-р улирал	Ажлын алба ЗУГ М.Мандах
	2.4. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах;	Үйл ажиллагааны зардлаар	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх;	Байгууллагын цахим хуудас, шилэн дансны мэдээлэлд төсөв, гүйцэтгэлийг нийтэлсэн байна.	жилдээ	ЗУГ М.Мандах Д.Болортуяа
	2.5. Эрчим хүчний хангамж, төлбөр тооцоотой холбоотой гомдол гаргаж буй хэрэглэгчдийн санал, хүсэлт, сэтгэл ханамжийн судалгааг хийх, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;	Үйл ажиллагааны зардлаар	- Гомдол гаргаж буй хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа хийх; -Гомдолтой холбоотой үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авах;	Судалгааны дүнд шинжилгээ хийж холбогдох арга хэмжээ авсан байна.	жилдээ	Ажлын алба ХОНГ Д.Алтантуяа
	2.6. Иргэд, хэрэглэгчдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч хуульд заасан хугацаанд шийдвэрлэж хариу өгөх;	Үйл ажиллагааны зардлаар	-Хэрэглэгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх;	Иргэд, хэрэглэгчдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	жилдээ	ХОНГ Д.Алтантуяа
	2.7. Дулаан түгээх, хангах компаниудын тусгай зөвшөөрлийн шаардлагын биелэлт, хэрэглэгчид үзүүлж буй үйлчилгээний чанарт газар дээр нь хяналт хийх;	Үйл ажиллагааны зардлаар	Газар дээр нь хяналт хийх компанийн тоо	15-аас доошгүй компанийг	1-р улирал	ТЗГ М.Ууганбаяр

				хамруулсан байна.		
Зорилго 3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах;						
3.	3.1. Эрчим хүчээр хангагчийн үйлчилгээнд "хувь хүнээс хамаарах хамаарал"-ыг бууруулах, хэрэглэгч цахилгааны хэрэглээгээ хянах, зохицуулах, төлбөрийн үнэн зөв байдлыг нягтлах, хяналт тавих зэрэг боломжийг бий болгох зорилгоор "Ухаалаг тоолуурын систем"-ийг нэвтрүүлэх ажлыг зохицуулалтаар дэмжих;	-	"Ухаалаг тоолуурын систем"-д хамруулсан хэрэглэгчдийн эзлэх хувь	Улсын хэмжээнд нийт хэрэглэгчдийн 79.5 %-ийг хамруулсан байх;	жилдээ	Ажлын алба ҮТГ Б.Эрдэнэбулган ТЗГ М.Ууганбаяр
	3.2. Хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах зорилгоор дулаан түгээх, хангах үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдүүдийн үйлчлэх хүрээг оновчтой болгох ажлыг үргэлжлүүлэх;	Үйл ажиллагааны зардлаар	Тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээнд өөрчлөлт оруулсан хуулийн этгээдийн тоо	Дулаан түгээх, хангах 10-аас доошгүй компанийн үйлчлэх хүрээнд өөрчлөлт оруулсан байх;	2-4-р улирал	ТЗГ М.Ууганбаяр
	3.3. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах шаардлагатай албан тушаалтнуудын 2025 оны ХАСХОМ-ыг тогтоосон хугацаанд нь гаргах, тайлан мэдээг зохих журмын дагуу гаргаж АТГ-т хүргүүлэх;	Үйл ажиллагааны зардлаар	Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;	Холбогдох албан тушаалтнууд хуулийн хугацаанд 100 % мэдүүлсэн байна.	2-р сарын 25	М.Мөнхтулга холбогдох ажилтнууд
	3.4. Байгууллагын сул орон тоонд томилогдохоор нэр дэвшсэн иргэний Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг АТГ-аар хянуулах, тус газраас хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилох, эсэх асуудлыг шийдвэрлэх;	-	Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;	Шаардлагатай албан тушаалтнуудыг 100 % хамруулсан байна.	жилдээ	Хорооны дарга Э.Түвшинчулуун ЗУГ
	3.5. Хорооны газар, хэлтсүүдийн үйл ажиллагаанд авилга, ашиг сонирхолын эрсдэлийг тодорхойлж үнэлгээ хийх, зөвлөмжөөр хангаж ажиллах;	Үйл ажиллагааны зардлаар	Байгууллагын үйл ажиллагааны онцлог тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх;	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг авсан байх;	2, 4-р улирал	Дотоод аудитор Ч.Цоодол

Хянасан:

Ажлын албаны дарга

Б.Болор-Эрдэнэ

Захиргаа, удирдлагын газрын дарга

А.Айдос

Боловсруулсан: ЭБАТ

 М.Мөнхтулга